**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 11 өдөр Дугаар А/06 Хажуу шинэ-Ус

Цалин шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.17, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3, 11 дүгээр хавсралт, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 , аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны А/17 дугаар захирамж, Сумын Засаг даргын 2021 оны 03 сарын 15-ны өдрийн Б/05 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагч нарын ажилласан хугацаа, Засгийн газрын 2023 оны Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 241 дүгээр тогтоолын 3,10 дугаар хавсралт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар хуралдааны ”Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 04 дүгээр тогтоолын дагуу 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн цалинг шинэчлэн тогтоосугай.

2.Төрийн албан хаагч нарын албан тушаал, нэрс, цалингийн зэрэглэл шатлал хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Үндсэн цалинг батлагдсан хэмжээгээр тооцож холбогдох шийдвэрүүдийг үндэслэн нэмэгдлүүдийг журмын дагуу олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч ( У.Сүнжидмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Т.АРИУНАА

Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 11-ний өдрийний 06 дугаар
захирамжийн хавсралт

| д/д | Нэрс | Албан тушаал | Албан тушаалын зэрэглэл | Үндсэн цалин | Нэмэгдэл | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зэрэг | Алба хаасан | Хавсарсан | Нууц | ЭБАТ | Улсаас 20 % | Аймгаас | Онцгой тохиолдол |
| Төрийн үйлчилгээ | | | | | | | | | | | | |
| 1 | Б.Даваасүрэн | Засаг даргын орлогч | УТ | 1,700,000 | | | 40% | | | | | 30% |
| 2 | М.Амарзаяа | 2-р багийн Засаг дарга | УТ | 1,250,000 | | | | | | | | 30% |
| 3 | Л.Батбаатар | 4-р багийн Засаг дарга | УТ | 1,250,000 | | | | | | | | 30% |
| Төрийн захиргаа | | | | | | | | | | | | |
| 4 | Н.Өлзийтогтох | ЗДТГ-ын дарга | ТЗ-5 | 1,597,000 | АТ-26% | 12% | | 10% | 10% | 20% | 10% | |